ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН БАТАЛСАН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ЯВЦЫН ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 15 Мандалговь хот

НЭГ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Аймгийн Засаг даргын баталсан захиргааны хэм хэмжээний актын 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээг хийж, захиргааны хэм хэмжээний актын үр дүнгийн талаар дээд байгууллага болон удирдлагуудыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээний зорилго оршино.

ХОЁР.ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт-шинжилгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.3-т заасан аргачлалын дагуу хийж үнэлгээний дүнгийн явцыг гаргасан**.**

ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Аймгийн Засаг даргын 2019 оны А/393 дугаар захирамжаар батлагдсан “Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох”, 2019 оны А/394 дугаар захирамжаар батлагдсан “Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох”, Байгаль орчин аялал жуулчлалын сайд Аймгийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/427, А/404 дугаар шийдвэрээр батлагдсан “Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журам батлах тухай” нийт 3 захирамжийн 29 заалтын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээг хийхэд хэрэгжилтийн дундаж 94 хувьтай байна.

Явцын дүнг хүснэгтээр харуулбал:

Д/Д	Шийдвэрийн нэр	Заалтын тоо	Хэрэгжилтийн хувь				Хэрэгжилтийн дундаж хувь
			100	90	70	30	
1	Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох тухай	12	8	4	-	-	97.5
2	Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох	11	9	-	1	1	90
3	Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох	6	5	-	1	-	95.0
	Дүнгийн нэгтгэл	29	22	4	2	1	94

ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо		29
Бүрэн хэрэгжсэн	100	25
Хэрэгжих шатандаа	70	3
Хэрэгжилт хангалтгүй	30	1
Хэрэгжилтийн хувь		94

ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ДАРААХ АРГА ХЭМЖЭЭНҮҮД ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.

1. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын хүрээнд:

2023 онд Төрийн аудитын газраас хог хаягдлын чиглэлээр хийгдсэн хяналт шалгалтын зөвлөмжийн хүрээнд аймгийн хог хаягдлын менежментийг сайжруулах 2024 оны төлөвлөгөө гарч хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Эрдэнэдалай сум хог хаягдлын олон нийтийн байцаагчаар 2 иргэнийг томилон тус бүр 660000 төгрөгөөр цалинжуулан ажиллуулсан. Луус суманд ЗДТГ-ын бүтцэд 1 орон тоо батлуулсан. Бусад сумдад журамд заасан хэрэгжүүлэх үйл ажиллагааг байгаль орчны мэргэжилтэн, байцаагч нар гүйцэтгэн ажиллаж байна.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Ш.МӨНХБАТ

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ 2024 ОНЫ ТҮЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024.01.02

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хөрөнгийн эх үүсвэр	Хугацаа	Хариуцах этгээд	Хамтран ажиллах
1	2	3	4	5	6	7	8	9
Зорилт 1. Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хог хаягдлын менежментийг боловсронгуй болгох удирдлага, зохион байгуулалтаар хангах								
1.1	Хог хаягдлын үйлчилгээний хуваамжийн хэмжээ, энгийн хог хаягдлыг цэвэрлэх цуглуулах, тээвэрлэх, бүсчлэх зардлын нэгж тарифыг аргачлалын дагуу бодитой тогтоож шинэчлэн батлах	Тариф батлагдсан сумын тоо	5	10	-	I-IV улирал	Сумдын ИТХ, ЗДТГ	БОАЖГ
1.2	Хог хаягдлын хуваамжийн төлөвлөгөө, хуваамжийн орлогыг зориулалтын дагуу бүрэн зарцуулах	Хог хаягдлын хуваамжийн биелэлтийн хувь	50%	65%	-	I-IV улирал	Сумдын ЗДТГ	Татварын хэлтэс
1.3	Сумдын төвөрсөн хогийн цэг нь стандартын шаардлага хангаж буй эсэхэд хяналт шалгалт хийх, зөрчлийг арилгуулах зөвлөмж өгсөн шаардлага хүргүүлэх	Хяналт шалгалтын тоо	-	3	ОНТ 2.0	I-IV улирал	БОАЖГ, БОХУБ	Сумдын ЗДТГ

Аймгийн хэмжээнд 483 хог ангилан ялгах савтай болсон байна.

Говь-Угтаал суманд 9, Өлзийт суманд 7, Хулд суманд 4, Гурвансайхан суманд 15, Дэлгэрцогт суманд 110, Дэлгэрхангай суманд 22, Сайнцагаан суманд 9, аймгийн хэмжээнд нийт 172 ширхэг ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав шинээр бий болж 311 байсан нь 483 болж нэмэгдэв.

2024 онд 107.3 тонн дахивар нөөц цуглуулан дахин боловсруулах үйлдвэр болон үйлдвэрлэгч ААН-д тушаасан. Эрдэнэс алт ресурс ХХК нь мөн 40.9 тн аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад тушаасан. Нийт ангилсан хог хаягдлын хэмжээ 148.2 тн.

Өмнөх онтой харьцуулахад 81.3 тн-оор буюу 242.9 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журмын хүрээнд:

Сумдад нийтийн эзэмшлийн талбайд хог хаягдал төвлөрөхөөс урьдчилан сэргийлж бүх нийтийн их цэвэрлэгээг 9 удаа зохион байгуулж нийт 540 га талбайгаас 25 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.

3. Агаарын чанарыг сайжруулах бүс тогтоох, бүсэд мөрдөх журмын хүрээнд:

ЧИП багц хэрэглэх сонирхолтой айл өрхүүдийн судалгаагаар 378 өрх хүсэлт ирүүлснээс орон нутгийн төсөв болон МАК ХХК-ын санхүүжилтээр 1 багцын үнийг 66 хувийн хөнгөлөлтэй нөхцөлөөр Сайнцагаан суманд 88, Баянжаргалан суманд 30, Дэлгэрхангай суманд 30, Дэлгэрцогт суманд 2, нийт 150 өрхөд уг багцыг олгосноор нийт 214 өрхийн хэрэглээнд нэвтрүүлээд байна.

Аймгийн төвийн 18 зууханд утаа шүүгч суурилуулагдсан. Утаа шүүгч суурилуулагдсанаар агаар бохирдуулагч эх үүсвэрээс гарч буй бохирдлыг 20%-иар бууруулах боломж бүрдсэн.

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого хийгдсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт 4005 галлагаатай айл өрх тоологдсоноос Сайнцагаан суманд 1902, Сумдын хэмжээнд 2103 айл өрх тоологдсон байна. 2023 онтой харьцуулахад айл өрхийн тоо 70-р буурсан ба нийт нүүрсний хэрэглээ 313.1 тн-оор буурсан байна. 2023 онд усан халаалтын 15-100 кВт хүчин чадалтай 87 зуух, 100-4200 кВт хүчин чадалтай 25 зуух тоологдсоноос 2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 15-100 квт хүчин ч адалтай з 84 болж буурсан б



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр Дундговь Мөн дугаартай

Агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол улсын Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 8.1.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.7, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2018 оны А/479 дүгээр тушаалыг үндэслэн Захирамжлах нь:

1. Аймгийн хэмжээнд агаарын чанарт хяналт тавьж агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлж тайлагнах, агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Аймгийн засаг даргын тамгын газрын дарга

Гишүүд: Байгаль Орчин, Аялал Жуулчлалын газрын дарга
Дундговь Цахилгаан Түгээх сүлжээ сангийн ерөнхий инженер
Авто Тээврийн Төвийн техник хяналтын үзлэгийн инженер
Сайнцагаан сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга

2. Агаарын чанарыг сайжруулах бүсийн агаарын чанарт хяналт тавьж ажиллан шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн агаар бохирдуулагч эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг журмын дагуу зохион байгуулж тооллогын дүнг нэгтгэн цахим санд бүртгэн , Засгийн газрын хэрэгжүүлэх агентлаг Ус цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Доржбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

Ердийн галлагаатай зуух														
Аймаг, сумын нэр		Нийт айл өрх	Гэрийн зуухны тоо		Гэрийн зууханд хэрэглэсэн түлшний хэмжээ, тн/жил				Байшингийн зуухны		Байшингийн зууханд хэрэглэсэн түлшний			
			Ердийн	Сайжруулсан	Нүүрс	Мод м³	сайжруулсан түлш	Бусад	Ердийн	Сайжруулсан	Нүүрс	Мод м³	сайжруулсан түлш	Бусад
Аймгийн төвийн хэмжээнд	*Дундговь аймаг Сайнцагаан сум*	1902	1231	221	4618.62	1165		271.5	362	88	1532	349.2		3
Сумдын хэмжээнд		2103	1198	476	3193.1	85.3		2320.4	315	431	1985	74.8		1197.1
Сум тус бүрт	*Говь-Угтаал*	137	66	23	236.5			121	40	8	129			70
	Дэлгэрцогт	146	61	37	155.5			254.5	21	27	106			101
	Өндершил	117	67	0	168			148	38	12	123			105
	Адаацаг	151	89	2	181			218	40	20	140			95
	Сайхан-Овоо	172	65	40	233	38.8		55.4	14	53	178.5	47.3		21.1
	Баянжаргалан	144	66	25	208			82	27	26	123.5			46.5
	Эрдэнэсгалант	341	6	185	480.5			402	8	142	370			344.5
	Луус	120	46	43	213			185.5	15	16	102			57.5
	Хүлд	169	59	45	341	46.5		99	13	52	247	27.5		42
	Цагаандэлгэр	67	34	3	108.6			44	30	0	82.3			34
	Дэрэн	141	102	7	180			177	20	12	60			61
	Дэлгэрхангай	215	90	49	331			296	21	55	223.5			159.5
	Өлзийт	84	50	17	172			139	9	8	52			37
	Гурвансайхан	99	80		185			99	19		48			23
Аймгийн хэмжээнд		4005	2429	697	7811.72	1250	0	2591.9	677	519	3517	424		1200.1

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Улсын нэгдсэн санд бүртгэлтэй аймгийн Засаг даргын баталсан захиргааны хэм хэмжээний актуудын хэрэгжилтийн явцад жил бүр хяналт шинжилгээ, үнэлгээг хийж холбогдох байгууллагуудад зөвлөмж өгч үр дүнг тооцон ажиллаж байна.

Дундговь аймагт хэрэгжиж буй 3 актын 2024 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 94 хувь буюу "**Тодорхой үр дүнд хүрсэн**" гэж үзэж үнэлгээний тайланг хүргүүлж байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 0,9 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд хуванцар цуглуулах болон 3 төрлөөр ангилан ялгах хогийн сав 311 байсан нь бол 2024 оны байдлаар 483 болж өмнөх оноос 172 ангилан ялгах зориулалт бүхий хогийн саваар нэмэгдсэн байна.

Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын 3 дугаар зүйлд суманд олон нийтийн байцаагч ажиллуулахаар тусгагдсан боловч Эрдэнэдалай сум хог хаягдлын олон нийтийн байцаагчаар 2 иргэнийг томилон тус бүр 660000 төгрөгөөр цалинжуулан ажиллуулсан. Луус суманд ЗДТГ-ын бүтцэд 1 орон тоо батлуулсан байна. Бусад суманд олон нийтийн байцаагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны хяналтын байцаагч болон мэргэжилтэн хариуцан гүйцэтгэн ажиллаж байгаа учраас олон нийтийн байцаагч ажиллуулах шаардлагагүй, төсөв хүрэлцэхгүй шалтгаанаар энэ журмын 3 дугаар зүйл хэрэгжихгүй байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2024 оны 12 сарын байдлаар 195,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 142,8 сая төгрөгийг төвлөрч хүрэх түвшинд хүрээгүй байна.

ТАВ.ЗӨВЛӨМЖ

Сумдын Засаг дарга нарт:

1. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг сар бүр жигд биелүүлж ажиллах.
2. Төвлөрсөн хогийн цэгийг хамгаалах, хаших хязгаарлах далан, хашаатай болгох.

Байгаль орчин аялал, жуулчлалын газарт:

1. Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмын 3 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах асуудлыг сумдын Засаг дарга нартай байгуулах гэрээнд тусгай заалт болгон оруулж хэрэгжилт үр дүнг хагас бүтэн жилээр тооцож, үр дүнгийн талаарх мэдээллээр удирдлагуудыг хангаж байх.
2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн талаар төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах.

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА Д.ДААРИЙМАА

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Б.СОЛОНГО